



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2020 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 157


Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.14, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/190 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу тус дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Рашаант хэсгийн хур хог хаягдлыг цэвэрлэх ажилд дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтэс /С.Аригуун/-т, хур хог хаягдлыг мэргэжлийн байгууллагаар цэвэрлүүлж, дахин үүсгэхгүй байх арга хэмжээ авч ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга Ж.Сандагсүрэнд тус тус үүрэг болгосугай.

2. Хур хог хаягдлыг цэвэрлэх, дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 10.000.000 /Арван сая / төгрөгийг Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт олон жил хуримтлагдсан хур хог хаягдлыг цэвэрлэж, дахин үүсгэхгүй байх арга хэмжээг авах зардлаас гүйцэтгэлээр санхүүжүүлж Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газрын дансанд шилжүүлэхийг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй .

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

